

**БАТЛАВ:**  
ДУНДГОВЬ АЙМГИЙН МАЛ  
ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГА  
Ш.МӨНХДҮҮРЭН



**ЗӨВШӨӨРӨВ:**  
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН МАЛ  
ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГА  
Ч.ОТГОНСҮРЭН

### **ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ**

2020 оны 10 дүгээр сарын 10 өдөр № .....

#### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01 тоот албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын 2020 оны 01/288 тоот албан бичигт тусгагдсан зарим заалтыг хэрэгжүүлэх, малчин өрхийн отор, нүүдэл түүнд мал эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, мэргэжил арга зүйн заавар, зөвөлгөө өгөх талаар хамтарч ажиллах харилцааг зохицуулна.

1.2 Энэ гэрээг нэг талаас Дундговь аймгийн Мал эмнэлгийн газар, нөгөө талаас Говьсүмбэр аймгийн Мал эмнэлгийн газар харилцан тохиролцож байгуулав.

#### **Хоёр. Гэрээний үндсэн нөхцөл**

2.1 Хоёр тал гэрээнд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

2.2 Гэрээний үйлчлэх хугацаа 2020 оны 10 дүгээр сарын 10-ны өдрөөс 2021 оны 10 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаатай.

2.3 Гэрээг хагас, бүтэн жилээр буюу 6 дугаар сарын 25, 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор 2 удаа дүгнэнэ.

2.4 Гэрээний хугацаа дуусахад хоёр тал харилцан тохиролцож гэрээг сунгаж болно.

#### **Гурав. Талуудын харилцан хүлээх эрх, үүрэг**

3.1 Оторлож буй малчин өрхтэй тухайн багийн Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх талаар гэрээ байгуулж, хамтран ажиллах.

3.2 Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, малчинтай байгуулсан мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх гэрээ нь энэ гэрээний салшгүй хэсэг болно.

3.3 Отор нүүдэл хийж буй малчин өрх бүрийг малын эрүүл мэндийн дэвтэртэй байлгах ба түүн дээр мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан тухай тэмдэглэгээ хийсэн байх.

3.4 Малчин өрх нь отор нүүдэл, шилжилт хөдөлгөөн хийх, отроос буцахдаа тухайн аймаг, сумын гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид хандан мал сүргээ эрүүл мэндийн үзлэгт хамруулж, мал эмнэлгийн гэрчилгээ авсан байх.

3.5 Малчин өрх нь отроос буцахдаа зүй бусаар хорогдсон мал амьтны сэг зэмийг цуглуулж устгах, хашаа хороо, бууцыг халдваргүйжүүлэх, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийлгэх талаар оторлосон нутгийн Мал эмнэлгийн тасагт мэдэгдэж, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжтэй хамтран уг ажлыг бүрэн гүйцэтгэх ба тухайн орон нутгийн удирдлага болон багийн Засаг даргад мэдэгдэх.

3.6 Мал, амьтны гоц халдварт өвчний голомттой бүс нутагт отроор өвөлжих, хаваржих тохиолдолд мэдрэмтгий мал сүргийг уг өвчний эсрэг вакцинжуулалтанд заавал хамруулсан байх.

3.7 Зайлшгүй шаардлагатай үед Мал эмнэлгийн ерөнхий газраас өгсөн чиглэлийн дагуу оторлож буй малчин өрхийн мэдрэмтгий мал сүргийг гоц халдварт, халдварт өвчний эсрэг нөхөн дархлаажуулалтанд хамруулах ажлыг зохион байгуулах.

3.8 Шаардлагатай тохиолдолд оторлож буй малчин өрхийн мал сүрэгт шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх үйлчилгээ, эмийн сангийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх.

3.9 Нүүдэл, шилжилт хөдөлгөөн хийж буй өрхийг малын гоц халдварт, халдварт өвчний голомттой аймаг, сумдын нутгаар дамжин өнгөрүүлэхгүй байх маршрутыг урьдчилан тогтоож өгөх.

#### **Дөрөв. Хариуцлага**

4.1 Энэхүү гэрээнээс үүсэх аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд зөвшилцөлд эс хүрвэл Монгол улсын зохих хуулийн дагуу шийдвэрлэнэ.

#### **Тав. Гэрээг цуцлах үндэслэл**

5.1 Хоёр талын аль нэг гэрээгээр хүлээсэн үүрэг, заалтыг зөрчвөл гэрээг цуцалж болно.

5.2 Гэрээ цуцалсан нөхцөлд аль нэг талд хохирол учирсан бол буруутай тал нь хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Дундговь аймгийн Мал эмнэлгийн  
газрыг төлөөлж:

МАЭМА-ны дарга



Ц.ГЭРЭЛ

Говьсүмбэр аймгийн Мал эмнэлгийн  
газрыг төлөөлж:

МАЭМА-ны дарга

Г.НАРАНЧИМЭГ